



**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН
СУРГАЛТЫН МОДУЛЬ ХӨТӨЛБӨРИЙН ЦАХИМ
ХИЧЭЭЛ АШИГЛАХ ГАРЫН АВЛАГА**



2016

АГУУЛГА

АГУУЛГА	2
ТАНИЛЦУУЛГА	3
ҮНДСЭН ЦЭС	4
ТАНИЛЦУУЛГА	5
СУРГАЛТЫН ЗОРИЛГО	6
ВИДЕО ХИЧЭЭЛ	7
СУРГАЛТЫН МОДУЛЬТАЙ АЖИЛЛАХ	7
ГАРЫН АВЛАГА	10
ХАМТЫН АЖИЛЛАГАА	11
ХОЛБОО БАРИХ	12

ТАНИЛЦУУЛГА

Энэхүү гарын авлагыг Тогтвортой хөгжлийн боловсролын сургалтын модуль хөтөлбөрийн цахим хичээлийг ашиглах суралцагч, хэрэглэгчдэд зориулан боловсруулав.

Швейцарын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр БОАЖЯ, БСШУСЯ-наас хамтран хэрэгжүүлж буй "Тогтвортой хөгжлийн боловсрол" төслийн захиалгаар Насан туршийн боловсролын үндэсний төвөөс энэхүү сургалтын модулийн хэвлэмэл хэлбэрийг боловсруулсан болно. Модуль нь тогтвортой хөгжил, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролын талаарх мэдээлэл, мэдлэг, үзэл санааг олон нийт, шийдвэр гаргагч, байгаль орчны мэргэжилтэн, сургуулийн өмнөх боловсролын багш, арга зүйчдэд хүргэхэд зориулагдсан.

Зорилго: Орон нутгийн түвшинд ТХ/НХ /ТХБ талаарх мэдлэг, ойлголт, чадвар бүхий сургагч багш бэлтгэх, улмаар насан туршийн боловсролоор дамжуулан бүх нийтэд түгээн дэлгэрүүлэх, үндэсний чадавхыг дээшлүүлэх

Үр дүн: ТХБ-ын энэхүү сургалтын модулийг судалснаар сургагч багш нарын ТХ/ НХ /ТХБ боловсролын талаарх мэдлэг ойлголт нэмэгдсэн байна.

Тогтвортой хөгжлийн боловсролын сургалтын модуль хөтөлбөрийн цахим хичээл


<http://www.ncle.mn/esd/>

The screenshot shows a website interface with a navigation menu at the top containing: Нүүр, Танилцуулга, Видео хичээл, Гарын авлага, Хамтын ажиллагаа, Холбоо барих. The main content area features a header 'ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН цахим хичээл' and a sub-header 'Нүүр'. The main text describes the course, mentioning the Swiss Agency for Development Cooperation (BOAJA) and the National Center for Lifelong Education (BSHUSYA). It states that the course is a result of a joint effort and covers various aspects of sustainable development. A central graphic shows a globe surrounded by icons of trees, wind turbines, and water, with the text 'БИД БАЙГАЛЬ ДЭСХИЙГ ЭЛЭГ ӨНГӨЛӨӨРӨН ӨВЛӨЖ АВААГҮЙ' and 'БИД ҮР ХОЙЧ ҮЕЭСЭЭ ЭЗЭЭЛЖ АВСАН ЮМ.' Below the text is a circular button labeled 'Үргэлжлүүлэх'.

Зураг 1. Тогтвортой хөгжлийн боловсролын сургалтын модуль хөтөлбөрийн цахим хичээлийн нүүр хуудас

ҮНДСЭН ЦЭС

Энэхүү цахим хичээлийн вебийн толгойн хэсэгт доорх агуулгын холбоосууд бүхий үндсэн цэс (Зураг 2) байрлана.



Зураг 2. Цахим хичээлийн үндсэн цэс

Үндсэн цэсний командуудын тайлбар

Хүснэгт 1.

Нүүр	Тогтвортой хөгжлийн боловсролын сургалтын модуль хөтөлбөрийн цахим хичээлийн эхлэл хэсэгт очих болно.
Танилцуулга	Тогтвортой хөгжлийн боловсролын сургалтын модуль хөтөлбөрийн төслийн талаарх танилцуулга бүхий мэдээлэл авах боломжтой.
Видео хичээл	Тогтвортой хөгжлийн боловсролын сургалтын цахим хичээлийн сэдэв бүрт харгалзах видео хичээлийг сонгон үзэх боломжтой.
Гарын авлага	Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн хүрээнд хийгдсэн энэхүү цахим хичээлийн сэдэв тус бүрт харгалзах Гарын авлага, Видео хичээл, Дадлага ажил зэргийг файл хэлбэрээр татаж үзэх боломжтой. Мөн цахим хичээлийг ашиглах хэрэглэгчийн гарын авлагыг татан авч хэвлэх боломжтой.
Хамтын ажиллагаа	Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн хамтрагч байгууллагуудын мэдээлэл авах боломжтой.
Холбоо барих	Энэхүү цахим хичээлийг эзэмшигч буюу “Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл” төслийн гүйцэтгэгч “Насан туршийн боловсролын үндэсний төв”-тэй холбоо барих мэдээлэл авах боломжтой.


ТАНИЛЦУУЛГА

Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн талаарх танилцуулга бүхий мэдээлэл авах боломжтой хуудас (Зураг 3).



Зураг 3. Танилцуулга хуудас

Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн танилцуулга, хэрэгцээ үндэслэл, сургалтын зорилго зэргийг эндээс (Зураг 4) харах боломжтой.



Зураг 4. Танилцуулга цэсний агуулга

СУРГАЛТЫН ЗОРИЛГО

Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн хүрээнд хийгдсэн сургалтын зорилго, үр дүнгийн талаарх мэдээлэл авах боломжтой (Зураг 5).

НОГООН ХӨГЖИЛ

Модулийн зорилго, үр дүн

<p>Зорилго: Орон нутгийн түвшинд ТХ/НХ/ТХБ-ын талаарх мэдлэг, ойлголт, чадвар бүхий сургагч багш бэлтгэх, улмаар насан туршийн боловсролоор дамжуулан бүх нийтэд түгээн дэлгэрүүлэх, үндэсний чадавхийг дээшлүүлэх</p> <p>Үр дүн: ТХБ-ын энэхүү сургалтын модулийг судалснаар сургагч багш нарын ТХ/НХ/ТХБ-ын боловсролын талаарх мэдлэг ойлголт нэмэгдэнэ.</p> <p>“ТХБ ба суралцахуй” модуль 1-ийн зорилт: Орон нутгийн НТБ-ын төв, нэгжийн багш нарын ТХ/НХ/ТХБ-ын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалтын модуль боловсруулах үйлийн баримжааг ялган таниулах.</p> <p>“ТХБ ба суралцахуй” модуль 1-ийн үр дүн: Орон нутгийн шийдвэр гаргагч, СӨБ-ын багш, арга зүйч нарт зориулсан, орон нутгийн онцлогийг тусган боловсруулсан модулийн анхны хувилбар бүтээгдэнэ.</p> <p>Сургалтын зорилтот бүлэг Энэхүү сургалтын модулийг бүх нийтийн насан туршийн боловсролыг дэмжих хүрээнд бүхий л оролцогч талууд хэрэглэх боломжтой.</p>	<p>Модулийн зорилт: ТХБ-ын сургалтын модулийг боловсруулж, хэрэгжүүлэх чадвартай сургагч багш бэлтгэхийн тулд “ТХБ ба суралцахуй” модуль 1, “ТХБ ба түүнийг багшлахуй” модуль 2 тус бүрийг хэрэгжүүлэх замаар сургалтын модуль боловсруулах үйлийн баримжаанд багш нарыг суралцуулах зорилтыг дэвшүүлсэн болно.</p> <p>“ТХБ ба түүнийг багшлахуй” модуль 2-ын зорилт: Орон нутагтаа тогтвортой хөгжих мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалтын модуль боловсруулах үйлийн баримжааг эзэмшүүлж, үнэлж хөгжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжинэ.</p> <p>“ТХБ ба түүнийг багшлахуй” модуль 2-ын үр дүн: Орон нутгийн шийдвэр гаргагч, СӨБ-ын багш, арга зүйч нарт зориулан боловсруулсан сургалтын модулиа туршиж, үнэлэх замаар модулийн сайжруулсан хувилбар бүтээгдэнэ.</p>
--	---

Зураг 5. Танилцуулга цэсний сургалтын зорилго командаар нээгдэх хуудас

ВИДЕО ХИЧЭЭЛ

Тогтвортой хөгжлийн боловсролын сургалтын модуль хөтөлбөр цахим хичээлийн видео агуулгыг эндээс сонгож судална. Видео хичээлийг хэдэн ч удаа үзэх боломжтойгоороо танхимын сургалтаар судлах лекцийн хичээлээс давуу юм.

Видео хичээл цэснээс дараах бүлэг сэдвүүд бүхий цахим хичээлүүдтэй холбогдох боломжтой.

- Тогтвортой хөгжил, ногоон хөгжил
 - Экологийн ул мөр
 - Тогтвортой хөгжил
 - Ногоон хөгжил
- Тогтвортой хөгжлийн боловсрол ба суралцахуй
- Уур амьсгалын өөрчлөлт, түүнд дасан зохицох нь
- Биологийн олон янз байдал, түүнийг хамгаалах нь
- Гамшгийн эрсдэл, түүнийг бууруулах нь
- Тогтвортой хөгжлийг дэмжсэн хэрэглээ ба үйлдвэрлэл


СУРГАЛТЫН МОДУЛЬТАЙ АЖИЛЛАХ

Үндсэн цэсний “Видео хичээл” сонголтоор энэхүү цахим хичээлд багтах модулиудаас өөрийн сонирхсон сэдэвт хамаарах агуулга бүхий сэдвийг сонгоход, тухайн бүлэгт агуулагдах дэд сэдвүүдийн нэрс бүхий цэс гарна, эндээс сонирхсон сэдвээ сонгож цахим хичээлийг эхлүүлнэ. Жишээ нь: “Тогтвортой хөгжил, ногоон хөгжил” гэсэн бүлэг сэдэвт багтах “Экологийн ул мөр” гэсэн дэд сэдвийг сонгоход (Зураг 6) энэхүү сэдэвт харгалзах видео хичээлийг хэрхэн судлах талаар тайлбарлая.

Нүүр	Танилцуулга	Видео хичээл	Гарын авлага	Хамтын ажиллагаа	Холбоо барих
		Тогтвортой хөгжил, ногоон хөгжил			Экологийн ул мөр
		Тогтвортой хөгжлийн боловсрол ба суралцахуй			Тогтвортой хөгжил
		Уур амьсгалын өөрчлөлт, түүнд дасан зохицох нь			Ногоон хөгжил
		Биологийн олон янз байдал, түүнийг хамгаалах нь			
		Гамшгийн эрсдэл, түүнийг бууруулах нь			
		Тогтвортой хөгжлийг дэмжсэн хэрэглээ ба үйлдвэрлэл			

Зураг 6. Видео хичээл цэсэнд багтах дэд сэдвүүдийн жагсаалт

Видео хичээлийн цэснээс сонгогдсон цахим хичээлүүдийн хуудас дараах бүтэцтэй байх ба цахим хичээлийн тоглуулагч хэрэгсэл бүхий хуудас үндсэн талбарт нээгдэнэ (Зураг 7).



Зураг 7. Цахим хичээлийн хуудсын бүтэц

Дээрх цахим хичээлийн тоглуулагч хэрэгсэл бүхий зургийн хувьд тоогоор тэмдэглэсэн даралт, командууд дараах үүрэгтэй.

1. Цахим хичээл бүхий агуулга тоглуулагч хэрэгслийн үндсэн мэдээллийн хэсэг;
2. Нээгдсэн хичээл бүхий тоглуулагч хуудсыг хаах товчлууур;
3. Тухайн сонгосон агуулга бүхий цахим хичээл дээрх холбоосууд, өөрөөр хэлбэл тухайн цахим хичээл дотор багтах дэд сэдвийн нэр ба үүгээр уг сэдэвт хамаарах агуулгын хэсэгт шилжинэ;
4. Тухайн хичээлийн дууг хаах, нээх командын даралт;
5. Тухайн хичээлийг түр зогсоох, буцааж үргэлжлүүлэх командын даралт;
6. Тухайн хичээлийн явцын төлөв, өөрөөр хэлбэл тухайн хичээлийн хэдэн хувийг судлаад байгааг эндээс мэдэх боломжтой;
7. Тухайн хичээлийг дахин эхлүүлэх \REFRESH\ командын даралт.

Тухайн сонгосон цахим хичээл дээрх холбоосуудаас (7-р зургийн 3-р команд дээр дарах) сонголт хийгээд тухайн хичээлийн агуулгын хэсэгт шилжинэ. Доорх жишээний хувьд “Экологийн ул мөр гэж юу вэ?” сонголтоор нээгдсэн цахим хичээлийн агуулгын бүтэц (Зураг 8) :

- ▶ 1 – Цахим хичээлийн агуулга харуулах үндсэн мэдээллийн хэсэг;
- ▶ 2 – Дараах даралт буюу дараагийн хичээлийн агуулга нээх товчлууур;
- ▶ 3 – Тухайн хичээлийн үндсэн агуулгын нүүр хуудас руу шилжих даралт;
- ▶ 4 – Тухайн хичээлийн уншигдаж байгаа агуулгыг текст хэлбэрээр харагдуулах даралт товчлууур.



Зураг 8. Сонгогдсон сэдэвт харгалзах цахим хичээлийн агуулгын бүтэц

ГАРЫН АВЛАГА

Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн хүрээнд хийгдсэн энэхүү цахим хичээлийн нийт агуулгыг багтаасан татаж авах боломжтой Гарын авлага, Танилцуулга слайд, Видео хичээл, Дадлага ажлын файлууд. Модуль бүрт багтах дэд модулийн сэдэв бүхэнд харгалзах файлууд бий. Эдгээрийг файл хэлбэрээр татаж үзэх боломжтой (Зураг 9).

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН цахим хичээл

Нүүр Танилцуулга ▾ Видео хичээл ▾ Гарын авлага Хамтын ажиллагаа Холбоо барих

Гарын авлага

Модулийн агуулга		Товчилсон үг	Гарын авлага татах		
№	Модулийн агуулга		Гарын авлага	Видео хичээл	Дадлага ажил
1	Модуль 1. ТХБ ба суралцахуй	4			
1.1	Тогтвортой хөгжил, ногоон хөгжил (өчигдөр, өнөөдөр, маргааш)	1			
1.1.1	Экологийн үл мөр				
1.1.2	Тогтвортой хөгжил				3
1.1.3	Ногоон хөгжил				
1.2	Тогтвортой хөгжлийн боловсрол ба суралцахуй			2	
1.2.1	Тогтвортой хөгжлийн боловсрол ба цогц чадамж				
1.2.2	Гадны удирдлагатай суралцахуйгаас өөрийн удирдлагатай суралцахуйд				
1.2.3	Сургалтын оролтод төвлөрсөн хөтөлбөрөөс сургалтын гаралтад төвлөрсөн хөтөлбөрт				
2	Модуль 2. ТХБ ба түүнийг багшлахуй				
2.1	Уур амьсгалын өөрчлөлт, дасан зохицохуй				
2.2	Биологийн олон янз байдал, түүнийг хамгаалах				
2.3	Гамшгийн эрсдэл, түүнийг бууруулах				
2.4	Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэл				

Зураг 9. Цахим хичээлийн бүх агуулга болон дадлага ажлын зааврыг багтаасан гарын авлагын жагсаалт

Дээрх зураг бүхий цахим хичээлийн агуулгыг багтаасан бүх Гарын авлага, Танилцуулга слайд, Видео хичээл, Дадлага ажлын файлуудыг татах холбоосууд:

- ▶ 1 – Гарын авлага PDF хэлбэрээр татах холбоос;
- ▶ 2 – Видео хичээлийг эхлүүлэх/үзэх холбоос;
- ▶ 3 – Дадлага ажлын заавар PDF файл татах холбоос
- ▶ 4 – Товчилсон үгийн тайлбар харах хэсэг.

ХАМТЫН АЖИЛЛАГАА

Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн хамтрагч байгууллагуудын мэдээлэл авах боломжтой (Зураг 10).



Зураг 10. Төсөлд хамтран оролцогч байгууллагуудын нэрсийн жагсаалт

ХОЛБОО БАРИХ

Энэхүү цахим хичээлийн талаар мэдээлэл авах, холбоо барих “Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл” болон төслийн гүйцэтгэгч “Насан туршийн боловсролын үндэсний төв” –тэй холбоо барих мэдээлэл агуулсан хуудас (Зураг 11).

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН цахим хичээл

Нүүр Танилцуулга Видео хичээл Гарын авлага Хамтын ажиллагаа Холбоо барих

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra
Swiss Agency for Development and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг

giz Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

UPPSALA UNIVERSITET

IZB Institute for International Cooperation in Education
University of Teacher Education Zug

НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Холбоо барих

<p>Насан туршийн боловсролын үндэсний төв</p> <ul style="list-style-type: none"> ★ Сургалт, судалгааны төвийн 603 тоот 📍 МУБИС-ийн 12-р байр, Бага тойруу-14, Улаанбаатар, Монгол улс ☎ +976 70135131 ✉ info@ncle.mn 🌐 www.ncle.mn 	<p>Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл</p> <ul style="list-style-type: none"> ★ Мидтаун офис, 4-р давхар 📍 Энхтайваны өргөн чөлөө 15/2, Олимпын гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс ☎ +976 75770989 ✉ avid.enkhjargal@giz.de 🌐 www.esd.mn
--	---

©БОАЖЯ
©2016 "Тогтвортой хөгжлийн боловсрол" төсөл
©Насан туршийн боловсролын үндэсний төв
Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан, @2016

Зураг 11. “Насан туршийн боловсролын үндэсний төв”–тэй холбоо барих мэдээллийн хуудас